МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИСС

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

2026.11.06 № 01/2065

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасан нам, эвслээс нэр дэвшигчдийн аль нэг хүйсийн төлөөллийн доод хэмжээг 20 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан сонгох, сонгогдох эрхийг бодитойгоор хэрэгжүүлэх, улс төрийн шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний бодлого, олон улсын холбогдох гэрээгээр хүлээсэн түр тусгай арга хэмжээ авах үүргийн биелэлтийг хангахад ач холбогдолтой байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн “Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал” бүлэгт жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн зохицуулалт байгаа хэдий ч түүний хэрэгжилтийг хангах механизм, хяналтын тогтолцоо, хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ, эрх зүйн үр дагаврыг нарийвчлан зохицуулаагүй байгаа талаар дурдсан.

Мөн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөлөлд нэр дэвших болон сонгогдох боломж, улс төрийн дэмжлэг, санхүүгийн нөөцийн хүртээмж зэрэг хүчин зүйл нөлөөлж байгааг Монгол Улсад хийгдсэн олон судалгааны үр дүн нотолж байна. Энэ нь нэр дэвшигчдийн хүйсийн харьцаанд квот тогтоохоос гадна уг шаардлагын хэрэгжилтийг бодитоор хангах эрх зүйн зохицуулалт шаардлагатайг харуулж байна. Харин квотын шаардлагыг хангаагүй тохиолдолд зөрчлийг арилгуулах журам, авах арга хэмжээ, эрх зүйн үр дагаврыг хуульд тодорхой тусгах шаардлагатай. Ингэснээр квотын зохицуулалтын хэрэгжилтийг бодитой хангаж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үр нөлөөтэй эрх зүйн баталгааг бүрдүүлэхэд нөлөөлөх юм.

Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, сонгогдох эрхийн хэрэгжилтэд нэр дэвшүүлэх үйл явц, сонгуулийн сурталчилгааны боломж, хэвлэл мэдээллийн оролцоо зэрэг хүчин зүйл нөлөөлж байгааг авч үзсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 оны нэмэлт, өөрчлөлтөөр нэр дэвшигчдийн аль нэг хүйсийн төлөөллийн доод хэмжээг 2024 оны ээлжит сонгуулиар 30-аас доошгүй хувь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь байхаар нэмэгдүүлж, нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 хүйсийн харьцаатай жагсаалтын дараалллыг баримтлахаар хуульчилсан. Энэхүү зохицуулалтын үр дүнд 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд 520 эмэгтэй нэр дэвшиж, 32 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдсон байна.

1500201804

Харин 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчдийн 32.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж, орон нутгийн бүх шатны ИТХ-д сонгогдсон нийт 8,031 төлөөлөгчийн 2,212 буюу 27.5 хувь, аймаг, нийслэлийн ИТХ-д сонгогдсон 796 төлөөлөгчийн 18 хувь нь эмэгтэй байв. Энэ нь орон нутгийн түвшний улс төрийн шийдвэр гаргах байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгааг харуулж байна.

Комиссын хийсэн "Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль: Эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт", "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль: Эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт" судалгаа болон Цогц хөгжлийн үндэсний төв ТББ-ын 2021 оны "Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл" судалгаанд эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хангах хууль зүйн баталгаа, улс төрийн намын дотоод дэмжлэг, нэр дэвшүүлэх үйл явцын ил тод байдал хангалтгүй, мөн насаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн тэгш бус оролцоо үүсэх зэрэг асуудлыг хөндсөн байна.

Иймд хүйсийн квотыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ түүний хэрэгжилтийг хангах хяналт, хариуцлагын тогтолцоо, нэр дэвшүүлэх үйл явцын ил тод байдал, эмэгтэй нэр дэвшигчдийн сонгуулийн өрсөлдөөнд оролцох тэгш боломжийг хуульчлан баталгаажуулах шаардлагатай байна.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэлийн "Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдал", 24 дэх илтгэлийн "Сонгох, сонгогдох эрх: 2024 оны сонгуулийн үйл ажиллагаа" бүлгүүдтэй дэлгэрэнгүй танилцахыг хүсвэл Хүний эрхийн Үндэсний Комиссын www.nhrcm.gov.mn албан ёсны цахим хуудасны "Эх сурвалж" цэс дэх Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл хэсгээс үзэх боломжтой.

ДАРГА Д.СҮНЖИД